

НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛ ТӨВИЙН
“АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖИЙН ХЭРЭГЖИЛТ”-Д ХЯНАЛТ
ХИЙСЭН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 12 сарын 09

Дугаар...

Баруун Урт.

ХЭЛЭЛЦСЭН нь:

Хурал 2022 оны 12 сарын 09-ны өдөр 14:00 цагт хурлын танхимд байгууллагын дарга, сургалтын менежер, нийгмийн ажилтан багш нар оролцон хуралдаж Насан туршийн боловсрол төвийн захирал М.Энэбиш удирдан хурал эхлэв.

Хэлэлцсэн асуудал:

Аймгийн засаг даргын захирамжийн хэрэгжилтийн байдалтай танилцах, тайлан боловсруулалтын үр дүнг танилцуулах

СОНССОН нь:

Насан туршийн боловсрол төвийн захирал М.Энэбиш хурлыг нээж хэлэлцэх асуудлыг танилцуулав.

Захирал М.Энэбиш:

- 2022 оны хяналт шинжилгээ үнэлгээний АЗДЗахирамжийн тайланг 12 сарын 10-ны өдөр sukhbaatar.igovernment.mn хаягаар цахимд оруулж дуусгана. 12 сарын 10-ны дотор тайлагнах Аймгийн засаг даргын захирамжийн хэрэгжилтийн биелэлтийг ажлын хэсэг танилцуулна уу.

Нийгмийн ажилтан А.Батбаатар:

- Энэ оны хагас жилээс эхлээд тайлагналт, хяналт шинжилгээний шинэ журам хэрэгжиж байгаатай холбоотой тайлагналтыг цахимаар үйлдэж байна. Цахим системд шивэгдэж ирсэн 24 захирамжын 30 заалтын хэрэгжилтийг тайлагналаа. 2022 онд 100%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж ажилласан байна.

Багш С.Ганборгил:

-АЗДЗахирамжинд хэрэгжүүлж хэвшсэн зарим нэг захирамжийг хасах саналтай байна. Жишээлбэл А/88 зарим асуудлыг зохицуулан журамлах тухай /2009-03-10 энэ захирамжийг дотоод журмандаа тусгасан хэрэгжүүлж хэвшсэн заалт байна.

Сургалтын менежер П.Уянга:

- Олон жил хэрэгжүүлж хэвшсэн заалт учраас миний хувьд ч бас хасах саналтай.

Нийгмийн ажилтан А.Батбаатар:

- Саналыг хүлээн авч А/88 зарим асуудлыг зохицуулан журамлах тухай /2009-03-10 энэ захирамжийг хасах хүсэлтийг явуулья.

Дарга М.Энэбиш:

- Үйл ажиллагааг базсан өгүүлбэрээр, үр дүнг тоо баримтанд тулгуурлан товч тайлагнах ажлын хэсгээс өгсөн зөвлөмжид анхаарч ажиллаарай.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Дээрх тайлангийн хэрэгжилтийн биелэлтэд ажлын хэсгээс өгсөн зөвлөмжид анхаарч ажиллах талаар чиглэл өгөв.

Тайланг 2022 оны 12-р сарын 10-ны дотор эцэслэж, sukhbaatar.igovernment.mn хаягаар цахимд оруулж батлагаажуулахад бэлэн болгох. Сургалтын менежер П.Уянга хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллаарай.

Хурал 14 цаг 20 минутанд дуусав.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

У.НАРАНЖАРГАЛ

ХЯНАСАН: ДОТООД ХЯНАЛТ ХАРИУЦСАН АЖИЛТАН:

П.УЯНГА

АЗДЗахирамж

1. **ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ**
Хяналт шинжилгээ үнэлгээний зорилго нь аймгийн бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөө, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад оршино.
АЗДЗахирамжийн хэрэгжилтийг журмын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу тооцож, биелэлтийн дундаж үнэлгээг гаргалаа.
2. **ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН**
АЗДЗахирамжийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайлагналт сайжирч, тухайн заалт бүрд чиглэсэн үйл ажиллагааг хийж гүйцэтгэж байна.
3. **ДҮГНЭЛТ:** АЗДЗ-ын биелэлтийг гаргахад хэрэгжүүлж хэвшсэн 3, хасах саналтай 3 заалт байна. Байгууллагын АЗДЗахирамжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж үйл ажиллагаа хэвийн гэж үзлээ.
4. **ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ / ЗӨВЛӨМЖ /**
АЗДЗахирамжийн дагуу тухай бүрд байгууллага дээр ажлын хэсэг, зөвлөлүүдийг байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө гарган ажиллуулах
Зөвхөн тухайн байгууллагын чиг үүрэгтэй холбоотой заалтуудыг оруулах